

**“РИ БАГШИЙН ТҮНШҮҮР” ХУУЧ ЯРИАНЫ ХҮҮРНЭЛ ДЭХ
ХОШИГНОЛ БҮТЭЭХ АРГУУД
Humor techniques in Oral narrative about “RI teacher”**

Г.Нандинбилиг
/МУИС/

Хууч яриа гэдэг бол бүх л цаг үеийн аман зохиолд байдаг жанр бөгөөд Ринчен багштаны тухай хошин хууч яриа нь монголын орчин үеийн аман зохиолын амьд уламжлалын тодорхой жишээ болно. Бид энэ удаад аман хүүрнэлийн хам сэдэв, хүүрнэн өгүүлэгчийн чиг үүрэг хийгээд аман зохиолын хошигнол бүтээх аргын талаар Ри багшийн тухай хошин хууч ярианы жишээн дээр авч үзэхийг зорьсон бөгөөд ардын уран зохиолч Тангадын Галсан гуайн хэвлүүлсэн “Ри багшийн түншүүр” ном болон академич Б.Ринчений мэндэлсний зуун жилийн ойд зориулан гаргасан “Домогт Ринчений домгууд оршивой” эмхэтгэлд орсон олон жишээнээс цөөн хэдийг авч судална.

Ард түмнийхээ дунд “Ри” багш гэж алдаршсан Бямбын Ринчений тухай хууч ярианы олонх нь эх хэлнийхээ баян тансаг үгсийн сангаа мэдэхээ больж, бичиг соёлоо гэжж байгаа шинэ цагийнхныг тэрээр хэрхэн шоглон сургадаг байсан талаар хүүрнэдэг. Тухайлбал монголын нэрт сурган хүмүүжүүлэгч, сэтгүүлч Н.Цэвэгээ гуайн ярьсан хуучаас Т.Галсан гуайн найруулан авсан нэгэн жишээг авч үзвэл:

“Гэгээрлийн яамны орлогч сайд Шагдарсүрэн гавьяатаар тодорхойлогдсон залуухан эмэгтэй багшийн хичээлд суужээ. Тэрхүү хичээл нь эх хэлний хичээл байв. Багш эелдэг дуугаар:

-За хүүхдүүд ээ, та нар эдэлж хэрэглэж байгаа хувцсаа нэрлэ дээ! гээд самбарт үзүүлэн хадсанд цовоо нэг охин:

- Форма, фартук, юбка, куурчик, лээнт, гялстуг гэжээ. Багш:

- Хэн нэмэх вэ? гэхэд өөр нэгэн хөвгүүн:

- Пальто, майк, түрсийк гэхэд хүүхдүүд инээлдэв гэнэ. Багш яльгүй ичингүйрэн:

- Одоо хичээлийн хэрэглээ нэрлэцгээе гэхэд нэг сэргэлэн хүү:

- Авторучка, пеналь, үсгийн касс гэжээ. Энэ мэтээр өрнөсөөр шинэ хичээл өндөрлөж гэнэ.

Сайд, хичээлд суусан өвгөн хоёр ангиас түрүүлэн гарлаа. Хичээлд суусан идэвхтэй өвөө нь хэл шинжлэлийн ухааны эрдэмтэн Б.Ринчен гуай байв гэнэ. Сайд:

- За, Ринчен гуай. Манай багшийн заасан монгол хэлний хичээл ямар санагдав? гэсэнд:

- Эрхэм сайд минь нүгэлтэй ч юм даа. Энэ чинь эх хэлний хичээл биш эрлийз, хэлний хичээл байна гэжээ (Домогт Ринчений домгууд оршивой, 2005, 22)

Энэ мэт нэгэн бүлэг хошин хууч ярианы хүүрнэлийн чиг үүрэг илэрхий бөгөөд тэр үеийн нийгэм дэх орос хэлний нөлөөг шүүмжлэн харуулахын зэрэгцээ “Бид монгол хэлээрээ ярьж буй гэж бодовч харь хэлээр ярьдаг болчих вий дээ” гэсэн айдас болгоомжлолыг өнөө, хойч үеийн монголчуудад ямагт өгч байх далд утгат мөн чанарт эдгээр хууч ярианы үнэ цэн оршино.

Хууч яриа гэдэг бол дүрслэн бодох авьяасын үүрэг оролцоотойгоор ертөнцийг ойлгож мэдрэх нэгэн арга зам билээ. Ри багшийн тухай эдгээр бүлэг хууч яриа нь нэг талаас эх хэлнийхээ оновчтой хэрэглээг эрхэмлэгч гол баатар, нөгөө талаас шинэ соёлыг даган орж ирэх харь хэлний үгсийн хэрэглээг ухамсартай ухамсаргүйгээр идэвхжүүлж байгаа сөрөг баатар гэсэн хоёр талын үзэл бодол, үг хэл, үйл хэргийг эсрэгцүүлэн харуулахдаа хууч хөөрөгчийн эрхэмлэн бахдах хийгээд хошигнон шоглох аргыг хэрхэн чадмаг хослуулан өгүүлэх байдлаас хамаараад хууч ярианы хүүрнэлийн үнэт чанар нь нэмэгдэж байдаг.

Мөн бидний эдгээр хууч яриаг таашаан сонсдог өөр нэг шалтгаан бол эх хэл соёлоо өмөөрөн тэмцэгчийн **хөрөг бэлгэдэлт дүр (icon)** болсон Ри багшийн сэхээлэг оюун санаа болоод онч мэргэн, цэцэн цэлмэг үг хэлэнд оршино. Социализмын үеийн үзэл суртлын хүлээсийг илчлэн харуулсан нэгэн бүлэг хошин хууч ярианаас бид сонгож болно. Жишээлбэл: Ардын уран зохиолч Тангадын Галсан “Ри багшийн түншүүр” хэмээх номын тэргүүн дэвтэрт хэвлүүлсэн “Асуултаар багалзуурдсан нь” хэмээх хууч ярианд:

“1945 оны тавдугаар сарын наймны өдрийн “Үнэн” сонинд “Зөвлөлтийн ялгуугсан улаан арми Гитлерийн фашизмыг бут ниргэлээ” гэсэн мэдээ нийтлэгджээ. Тэр үед Ц.Дамдинсүрэн, Б.Ширэндэв, өвгөн бичээч Г.Навааннамжил зэрэг манай сэтгүүлчид нам төрийн гол хэвлэл “Үнэн” сонинд ажилладаг байжээ. Харин дээрх мэдээг Б.Ринчен гуай бичсэн юмсанж. Гэтэл өглөөгүүр хэн нэгэн том дарга утастаж:

-Та нар яасан эргэлзээтэй юм бичдэг этгээдүүд вэ? “Ялгуугсан” гэдэг чинь феодализмын хэллэг биш гэх үү? Энэ мэдээ нэг л ойлгомжгүй байна гээд л банга буулгаж эхлэв гэнэ. Ийнхүү аянга цахилуулж байгаа эрхэм хэн болохыг албархаг ааш, нутгийн аялга хоёроор нь таниад авсан Ринчен гуай:

- Ялгуугсан гэдэг бол ялж төгс дийлсэн гэсэн утгатай монгол үг. Манай буриадад ч, танай ойрдод ч бас тийм л утгатай. Зөвлөлтийн баатарлаг улаан арми дайснаа дарсныг итгэхгүй, эргэлзээд байдаг та ер нь хаанахын хэн гээч байна? гэж асуултаар багалзуурдсанд үл үзэгдэгч эрхэм утсаан бушуухан тасалж орхижээ. Ри гуай элгээ хөштөл инээсэн гэдэг. Хурын үүлгүй тэнгэрээс хуурай аянга буулгагч тэр эрхэм нь угтаа Ю.Цэдэнбал байсан гэдэг. Эрдэмтэн дарга хоёрын эв энэ өдрөөс хойш бүр ч цавтсаныг түүх гэрчилнэ” (Т.Галсан, 1990, 11-12)

Энэхүү хошин хуучийн хүүрнэлийн чиг үүрэг нь өмнөх хуучийн адил тийм ч шууд ил тодорхой биш байж болно. Нарийвчлан ажиглавал тус хуучийг хүүрнэгч утасны цаадах том даргын мөхөс байдлыг илчлэн шантлах хүслээ Ри багшийн зан төрхөөр дамжуулан илтгэж буй нь мэдэгдэнэ. Магадгүй зарим нь үүнийг омог бахдал, эсвэл бардам зангийн тухай өөр арга замаар үзүүлсэн гэж ойлгож болно. Эсвэл бүр харилцан ярианы нь тоглолт, мэтгэлцэл солбицолд нь илүү татагдан дурлаж байж ч болох юм.

Ерөөс хууч ярианы судлалд хам сэдвийг сайтар анхаарах хэрэгтэй юм. Дээрх хууч ярианд хоёр хам сэдэв байна. Нэг нь илт утгаараа монгол хэл соёлын хам сэдэв байна. Ри багшийн тухай энэ мэт хошин хууч ярианууд нь хэл соёлоо хадгалах, эсвэл шинэ соёлыг дагаж орж ирсэн харь үгсийг хэрхэн эх хэлэндээ буулган орчуулах талаар зөвлөж байдгийг бид мэднэ. Энэ бүхэнтэй зэрэгцээд соёлын хам сэдвийн чинадад нийгмийн хам сэдэв байна. Ри багштаны намтрын хам сэдвээр дамжаад тэр цагийн нийгмийн үзэл суртал, дарамт шахалтыг мэдэх нэгэнд нь сануулж, мэдэхгүй нэгэнд нь таниулж байна.

Хошин хууч яриа гэдэг бол ямар нэг хэмжээгээр бичил үнэлгээ юм. Тодруулж хэлбэл, Ри багшийн тухай хошин хууч ярианы эдгээр хам сэдвийн тусгай аспектиуд нь социализмын үеийн үзэл суртлын тухай мэдүүлэх гэсэн уншигч сонсогчдод зориулсан нэмэлт зүйлс болно. Хууч ярианы хам сэдвийг ойлгосноор уншигч сонсогчид түүхэн цаг үеийн нөхцөл байдлыг танин мэдээд зогсохгүй шүүн тунгааж, үнэлж дүгнэхэд тусалдаг.

Хууч ярианы хүүрнэлийн бүдүүвч нь маш товч, цөөн үгийн хүрээнд байдаг нь сонсогчийн анхаарал сонирхол төвлөрөх богино хугацаанд гол санаагаа хүргэх гэсэн зорилготой нь холбоотой. Ри багшийн тухай хошин хууч яриаг хүүрнэл зүйн задлан шинжилгээний сонирхдог гол сэдвүүдээр авч үзвэл:

1. **Үйл явдлын зөрчил ба утга санааны тогтмол**

Ри багшийн тухай хууч ярианы зөрчил нь өнгөц харахад гадаад зөрчил мэт боловч дүр хоорондын үзэл бодол үйл хэргийн эсрэгцлээр дамжин илэрч буй монголын нийгэм соёлын дотоод зөрчил байдаг. Бүр тодруулбал олонх тохиолдолд эх хэл соёлын ариун байдал зэрэг нийгэм соёлын хам сэдвийн хүрээнд асуудал дэвшүүлээд, эсрэгцэн буй хоёр хүчний зөрчил маргааны өрнөл нь Ри багшийн эх хэлээ эрхэмлэх үзлийн ялалтаар төгссөн байдаг онцлогтой. Энэхүү бардам төгсгөлөөр нь хүүрнэн өгүүлэгчийн үзэл хандлагыг мэдэж болох ба уг хууч яриаг хүүрнэгчид нь сонсогч олонд нөхцөл байдлыг тунгаан цэгнэх замаар хэрэг явдалд дүгнэлт хийх, хэрвээ иймэрхүү үг үйлдэлтэй тулгарах юм бол та ч бас ингэх хэрэгтэй гэсэн зурвас санааг илгээж байна.

2. **Хүүрнэлийн дотоод эмх цэгц дараалал буюу хүүрнэлийн боловсруулалт**

Хууч ярианы хүүрнэгч нь хүүрнэлийн туршид Ри багшийн хэлсэн үг, хэрэг явдлыг мэдээлэх нэг л чиг үүрэгтэй. Ри багшийн зан төрх нь нэлээд хэмжээгээр бэлгэ тэмдгийн шинжтэй болсноор Ри багш гэсэн нэрийг хэлэнгүүт хүүрнэлийн баатрын үзэл бодол жанжин шугамыг сануулж эхэлнэ. Хүүрнэгчийн хүсэлтээс шалтгаалан өөрчлөлт орох боломж бараг байхгүй. Өөрөөр хэлбэл, уншигч сонсогчийн хяналт нь хэт зохиомол зүйлийг эсэргүүцэж, хүүрнэн өгүүлэгчийн зүгээс өөрийн дураар шинэ санаа нэмж оруулахыг зөвшөөрөхгүй тийм тогтмол бүтэцтэй болжээ.

Хүүрнэлийн боловсруулалтыг тодруулахын тулд хүүрнэлийн янз бүрийн түвшинд маш анхааралтай хандах хэрэгтэй. Хүүрнэлийн залгаа буюу хүүрнэх ба илэрхийлэх гарцын хооронд анализ хийж үзвэл, хоёр хүүрнэл нэгдэж байгаа тохиолдолд эхний хүүрнэлд гол баатар болж байсан хүн хоёрдугаар хүүрнэлд хүүрнэгч болж болно.

3. **Зан төрхийн жишиг загвар.** Өгүүлэгч гэдэг бол тухайн хүүрнэлийнхээ дүр болоод үйл явдлыг тодорхойлдог ч монгол аман хууч ярианы төрөл зүйлд Ри

багшийн дүр нь хэл соёлоо өмөөрөн тэмцэгчийн **хөрөг бэлгэдэлт дүр (icon)** болон тогтсон байна. Дүрийг задлан шинжилнэ гэдэг бол зан төрхийг нээнэ гэсэн үг. Ри багшийн тухай хууч ярианд Ри багшийн зан төрхийг бүтээхдээ харилцан ярианы аргыг өргөн хэрэглэсэн байна. Харилцан ярианы солбицолд Ри багш олонхдоо бусдын алдаатай яриа, зөрүүтэй үзэл бодлын эсрэг оновчтой эсрэг хариуг өгөх маягаар шийдвэрлэсэн байна. Жишээ нь: Эх хэлний хичээл биш, эрлийз хэлний хичээл байна гэх мэт

Өөрийн нэр нь дүрийг бодит бие хүн гэдгийг тунхаглахын зэрэгцээ нийгэм ба соёлын сэдэвт татаж байна. Бидний судлан буй бүлэг хууч ярианд гол баатар болох Ри багшаас гадна тэр цагийн эрх мэдэлтэн их бага дарга нараас эхлээд залуу багш, гэнэн багачуул гээд өгүүлэгчийн сонгосон хэн ч байсан ямагт Ри багшийн үзэл бодол үйл хэрэгтэй харшилдаж буй хүчнийг төлөөлж байдаг юм. Ри багшийн түншүүр хууч ярианы өгүүлэгч нь түүний бэлэн цэцэн егөө үг, онч мэргэн ухааныг бусад дүрийн байр байдалтай эсрэгцүүлэн үзүүлдэг.

4. **Хүүрнэлийн далд санааг илэрхийлэх ялгаатай дуу хоолой \voices\.** Нарратологи буюу өгүүлэгчээр нь дамжуулан өгүүлэмжийг судлах аргын үүднээс авч үзвэл аливаа аман хууч яриа нь аливаа хүүрнэл зохиолын нэгэн адил нэгдүгээр биеэс буюу өгүүлэгч нь өөрөө тухайн зохиолын аль нэг баатар мэтээр үйл явдлыг хүүрнэдэг, эсвэл өгүүлэгч нь гуравдугаар биеэс буюу өгүүлэмжийн гадна талд байгаа нэгний үүргээр хүүрнэдэг. Харин “Ри багшийн түншүүр” нэрт нэгэн бүлэг хууч ярианы хүүрнэлийн онцлог бол **өгүүлэгч** нь үйл явдлыг өгүүлэхдээ гол баатар буюу гэрч баатрын дүрээр нэгдүгээр биеэс өгүүлэх бус, харин **гуравдугаар биеэс** буюу Ри багшийн хэрхэн хэлж ярьж байсныг дамжуулж буй, хүүрнэлийн гадна орших нэргүй хүүрнэгчийн байдлаар, эсвэл Ри багштан хэн нэгэнтэй ярьж байгаа **хоёр биеийн харилцан яриагаар** үзүүлсэн байна.

Ри багшийн тухай хууч ярианы хүүрнэл бүтээх аргыг ангилж үзвэл дараах гурван арга маяг байна. Үүнд:

А. Хүүрнэн өгүүлэгч өөрөө **бүхнийг мэдэгч маягаар гуравдугаар биеэс хүүрнэж**, дүрийн үзэл бодол болоод бүх мэдээллийг өгөх арга маяг

Б. Хүүрнэн өгүүлэгч үйл явдал өгүүлэмжийг хөтөлж явснаа гэнэт зайгаа тавьж өгөөд, бусдаас дам сонссон маягаар “...тэгсэн гэнэ, тэгж гэнэ” гэхчлэн, **хариуцлагаа өөр нэгэнд түлхэх** арга маяг

В. Хүүрнэн өгүүлэгч хөндлөнгөөс ороод яриад тайлбарлаад байх боломжгүй, драмын маягаар өгүүлэмжийг зохион байгуулж, **баатруудын үйл хөдлөл, хэл яриагаар дамжин, зан төрх нь өөрөө илрэн гарах** арга маяг. Тодруулж хэлбэл, баатрууд нь хэрэг явдалд өөрсдөө шууд орж, харилцан ярилцаад, тэрхүү яриан дунд нь үзэл ухамсрын нь ертөнц аажимдаа ялгаран тодорч ирэх арга маяг

Эдгээрийн эхний хоёр нь Ри багшийн тухай хууч ярианы хүүрнэл бүтээх шалгарсан арга болно. Ийм төрлийн хүүрнэлд хүүрнэгч нь алга болсон мэт сэтгэгдэл төрүүлдэг. Гэвч сэтгэл хөдлөл, үнэлэлт шүүлт зэрэг янз бүрийн хүчин зүйлс түүний байгааг гэрчилж өгдөг.

Хүүрнэн өгүүлэгчийн хэл яриагаар мөн өгүүлэгчийн зүгээс зохиолын гол баатарт хэрхэн хандаж харьцаж байгаа, юу гэж үнэлж сэтгэж байгаа **хандлага** нь илэрч байдаг. Бидний ажигласнаар, олонх хууч ярианы дотор хүүрнэн өгүүлэгч

нь гол баатрынхаа буюу Ри багшийн **дуу хоолойгоор** ярьдаг. Чухам үүгээрээ хууч яриаг хүүрнэн өгүүлэгч ба хэвлэн нийтлэгчид нь өөрийн үзэл үнэлэлтээ илтгэж байдаг байна. Жишээлбэл, бидний судалж буй энэ бүлэг хууч ярианд өгүүлэгчийн яриагаар олон жил эх хэл соёлынхоо дархан манаанд зогссон өвгөн эрдэмтний үзэл бодол, үг хэл, үйл хэргийг илэрхийлэн гаргахын зэрэгцээ гадаад хэл суртлаар хоосон чамирхсан ухваргүй нэгэнтэй тулгаруулж тийм нөхцөл байдалд татан оролцуулах замаар баатаргаа хандах хандлага болон мөн өгүүлэгчийн эх хэлдээ хандах хандлага “**дуу хоолойгоо**” дам илэрхийлсэн байна.

5. Уран сэтгэмж ба бодит явдлын харилцан нэвтрэлцэл.

Түүх өрнөн болж өнгөрөх цаг ба орныг утга зохиол урлаг судлалд орчин гэх бөгөөд энэ нь зөвхөн бодит орчин тойрныг оруулаад зогсохгүй тэр цагийн зонхилох үзэл санаа, ёс заншил, үнэт чанар болоод итгэл үнэмшлийг агуулдаг. Ри багшийн талаарх хошин хууч ярианы хэрэг явдлын орчин нь орос хэлний нөлөөт, социализмын үеийн Монгол орон болно.

Социалист дэглэмийн үеийн эх хэл соёлын асуудалд бараг цорын ганц сөрөг хүчин болж байсан бие хүн бол Бямбын Ринчен байсан бөгөөд тэрээр өөрийн тэмцлээ хошигнолоор илэрхийлдэг байжээ. Ри багшийн тухай хошин хууч ярианы хэрэг явдлууд нь тодорхой түүхэн бодитой байсан хэдий ч басхүү хууч яриаг хүүрнэн өгүүлэгчид болоод эмхэтгэн нийтлэгчдийн зүгээс нэмэрлэж хачирласан уран сэтгэмжийн зүйлс ч буй. Энэ нь хууч ярианы тогтмол нэг шинж чанар болох амаас ам дамжин хүүрнэн ярих аман шинжтэй нь холбоотой билээ. Ам дамжин хүүрнэх явцад болсон явдлын дээр уран сэтгэмжийн зарим шинж орж эхлэх нь зүй ёсны хэрэг билээ.

Манай зарим сэхээтнүүд Ри багшийн цэцэн цэлмэг үгийг хойч үеийнхэнд хүргэх, улмаар өнөөгийн нийгмийн адил мөн чанартай үзэгдлийн эсрэг сөрөг хариулт, дуу хоолой болгон барих зорилгоор эмхэтгэн хэвлүүлж, олны хүртээл болгож байна. Чингэхдээ орчин нөхцөлийн өөрчлөлтөөс болоод зарим талаар илүү үнэмшилтэй болгохын тулд бодит зүйлийг нарийвчлан дүрслэх, бодит хүмүүсийг нэрийг олноор оруулж өгөх зэргээр баяжуулсан байдаг.

Бодит хэрэг явдал болоод уран сэтгэмжийн аль нь ч байсан эдгээр хууч яриа нь орчин цагийн аман зохиолын нэгэн гол жанр болох хошин хууч ярианы бодит жишээ мөн болно. Ри багшийн түншүүр хууч ярианы хошигнол бүтээх аргыг авч үзвэл дараах мэт байна. Үүнд:

А. Үг хэлний хошигнол Хошигнол бол эцсийн бүлэгт хэлний тусгай хэрэглээгээр үүсэж бий болдог. Үүнд: Авиа ижилсүүлэх юм уу дуутай дуугүй эгшиг гийгүүлэгчийг олон давтах маягаар ижилсүүлэл болоод эсрэгцүүллийг бүтээж инээлгэх, үг хэлийг зориуд гажуудуулж алдаатай ярих үгсийн наадгай \каламбур\ юм уу Далан худалчийн маягийн учир зүйг гажуудуулсан үг хэллэг, тонгоргон яриагаар наадах зэрэг байдаг. Жишээлбэл: “Хүн хүний шүтээн өөр” гэсэн шог ярианд

- *Ном ном гээд л гандангаар гүйгээд байна уу гэж асуусан нэгэнд Ринчен гуай*
- *Та нам нам гэдэг хүн байсан, одоо лам лам гэдэг хүн болоо шив дээ гэж хэлсэн,*

Алтай Бээжин Туулын өндөр сайхан ресторанууд

Алтанбулаг, Орхон, Сэлэнгийн хүйтэн сайхан пивонууд... (Т.Галсан, 1990,18)

"...Цэдэнбал нэрийг орчуулбал юу гэсэн утгатай бол гэж шивнэн асуусанд

Нэрийн дунд орсон Б үсгийг нь хасчих, тэгээд л болох нь тэр гэжээ" (Т.Галсан, 1990, 22) гэсэн үгийн наадам зэргийг дурдаж болно.

Б. Нөхцөл байдлын хошигнол бол үл ойлголцол болоод голдуухан зохиогчийн дүрслэн бодож олсон сэдэл хатгаасын дундах нөхцөл байдлыг үүсгэдэг. Сонсогчид тухайн дүрийг их хөгийн байдалд байгааг нь үзээд инээхээс аргагүй болдог. Жишээ нь: нэгэн эрх мэдэлтний Ринчен гуайг феодализмын хэллэг хэрэглэсэн гэж буруутгах гээд өөрөө эцэст нь мэдлагдаж буй нөхцөл байдал.

В. Зан төрхийн хошигнол. Дүрийн зан төрх бол мөн ялгаагүй хошигнолын эх булаг болдог. Нэг хэсэг нь алиалж наргиж, нөгөө хэсэг нь гэнэн тэнэгээрээ хүний инээд хүргэж байдаг. Жишээ нь: Монгол хэлний хичээл дээр форма, фартук, юбка, куурчик, лээнт, гялстуг гэхчлэн нэрлүүлж буй залуу багшийн гэнэн үйлдэл болон зочин хүнийг их багаар алагчлах гэрийн эзэгтэйн зан төрх зэргээр хошигнол бүтээжээ.

Энэ бүхнээс дүгнэвэл

Ри багшийн тухай хууч яриа нь цаг цагийн ном бичгийн хүмүүсийн хууч хөөрөх сэхээлэг нэгэн гол сэдэв болж өрнөсөөр, улмаар монгол аман зохиолын Далан худалч бэлэн Сэнгээгийн үлгэрийн адил нэгэн гол баатартай орчин цагийн богино хүүрнэл аман зохиолын цуврал хэлбэрийг олсон байна.

1. Эрдэмтэн зохиолч Бямбын Ринчен нь монголын орчин цагийн аман зохиолд монгол хэл соёлоо өмөөрөн тэмцэгчийн хөрөг бэлгэдэлт дүр (icon) болсон байна.
2. Хүүрнэл зүйн онол шинжилгээний үүднээс авч үзвэл эдгээр хуучийг өгүүлэгчид нь Ри багшийн тухай хууч яриагаар дамжуулж, өөрийн үзэл хандлага дуу хоолой (voice)-гоо илэрхийлдэг байна.
3. Ри багштаны тухай хошин хууч яриаг үгийн урлагийн хошигнол бүтээх аргын үүднээс авч судалбал үг хэлний хошигнол болоод зан төрхийн хошигнол, нөхцөл байдлын хошигнолыг чадварлаг эзэмшсэн байна.

ABSTRACT

Oral narrative of teacher Ri has been extended as main intellectual topic of narration for writers from generation to generation. In others words, it has already taken place on oral narrative series with a main role as Dalankhudalch story.

1. Professor and writer Rinchen Byambiin is considered as an icon, who fights to protect Mongol language and culture in Mongolian modern oral literature.
2. According to narrative theory analysis, writers used to express their voice through oral narrative of teacher Ri.
3. If we look at the oral narrative of teacher Riin the sentence styling for humor, it is sophisticated with lexical humor, behavioral humor and conditional humor.

НОМ ЗҮЙ

1. Билгүүн номч Бямбын Ринчен (1990). Наян тавны нь сүүдэр зэрэгцэх жилд зориулбай. Эмхэтгэж эрхэлсэн Г.Аким. УБ.
2. Галсан, Т. (1990) Ри багшийн түншүүр (Ёж, егөө, шог). УБ.
3. Галсан, Т. (2005) Домогт Ринчений домгууд оршивой. Академич Б.Ринчений мэдэлсэний 100 жилийн ойд. УБ., 2005
4. Fennigan Ruth (1991) Oral traditions and Verbal Arts. *A Guide to Research Practices*. Routledge